



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2021/ 20 /СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Глобал капитал аудит ХХК Аудитор: Д.Энхтуяа Утас: 99449299 Цахим хаяг: Enkhtuya@gmail.com
-----------------------	---

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3.Аудитын тайлан .....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	<b>Error! Bookmark not defined.</b>



Г БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНГОВЬ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА М.ӨЛЗИЙЖАРГАЛ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 2/85

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага аймгийн ЭМГ, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлтийг гаргасан байна. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй эмнэлгүүдтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлэх, ажил үйлчилгээний чанарын асуудлыг тухайн шатны засаг дарга хэрэгжүүлдэг.

Тус байгууллага нь Ковид-19 цар тахлын онцгой дэглэмийн үед Аймгийн онцгой комисс, Эрүүл мэндийн газраас өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

2021 А4 ТООТ

005020044

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,385,358.42	19,619,434.34
33	АВЛАГА	2,144,178.42	58,000.00
335	Бусад авлага	2,144,178.42	58,000.00
3351	Байгууллагаас авах авлага	2,144,178.42	58,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,241,180.00	19,561,434.34
351	Түүхий эд материал	00.00	8,922,045.34
35130	Эм боох материал	00.00	8,922,045.34
354	Хангамжийн материал	9,241,180.00	10,639,389.00
35410	Бичиг хэргийн материал	720,080.00	632,450.00
35420	Аж ахуйн материал	5,536,250.00	4,769,850.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	800,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,775,900.00	4,437,089.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	292,691,730.33	425,608,608.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	292,691,730.33	425,608,608.79
392	Биет хөрөнгө	285,685,730.33	418,602,608.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	226,072,142.88	375,666,064.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,875,494.00	-11,750,988.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,610,000.00	33,610,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,017,916.58	-11,392,916.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	102,675,925.87	109,430,925.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	-70,372,389.08	-81,540,810.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,731,550.00	12,731,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,558,043.98	-8,488,297.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,989,000.00	1,989,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,569,044.78	-1,651,919.78
393	Биет бус хөрөнгө	7,006,000.00	7,006,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,456,000.00	7,456,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	304,077,088.75	445,228,043.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,644,062.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,644,062.75
413	Өглөг	00.00	3,644,062.75
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	175,794.75
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	2,803,568.00
4136	Бусад өглөг	00.00	664,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	664,700.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	304,077,088.75	441,583,980.39
51	Засгийн газрын хувь оролцоо	304,077,088.75	441,583,980.39
511	Засгийн газрын оруулсан капитал	296,933,621.64	296,933,621.64
51101	Өмч: - төрийн	296,933,621.64	296,933,621.64
512	Хуримтлагдсан үр дүн	-51,506,485.92	86,000,405.72
51210	Өмнөх үеийн үр дүн	-51,506,485.92	-51,506,485.92
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	137,506,891.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	58,649,953.03	58,649,953.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	304,077,088.75	445,228,043.13

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	374,901,480.00	561,844,533.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,200,000.00	166,605,317.34
120	Нийтлэг татварын бус орлого	5,600,000.00	157,683,272.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,600,000.00	157,683,272.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,600,000.00	157,683,272.00
122	Тусламжийн орлого	5,600,000.00	8,922,045.34
122001	Хандив тусламж /дотоод/	5,600,000.00	8,922,045.34
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	363,701,480.00	395,239,216.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	318,383,800.00	333,572,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	318,383,800.00	333,572,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	9,055,376.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	9,055,376.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,583,900.00	23,683,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,583,900.00	23,683,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,733,780.00	28,927,940.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,733,780.00	28,927,940.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	375,977,509.61	424,337,641.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	375,977,509.61	424,337,641.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371,019,716.41	409,985,545.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,490,275.00	260,494,887.00
210101	Үндсэн цалин	220,821,800.00	237,359,387.00
210102	Нэмэгдэл	5,661,592.00	23,135,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,000,013.58	32,983,917.17
210201	Тэтгэврийн даатгал	19,629,614.93	22,839,149.79
210202	Тэтгэмжийн даатгал	1,287,761.65	2,606,647.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	938,353.00	2,085,319.07
210204	Ажилгүйдлийн даатгал	215,602.00	495,707.69
210205	Эрүүл мэндийн даатгал	2,928,682.00	4,957,092.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,086,122.00	20,302,055.00
210301	Гэрэл, цахилгаан	6,893,578.00	1,902,055.00
210302	Түлш, халаалт	8,792,544.00	18,200,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,695,214.76	38,340,320.00
210401	Бичиг хэрэг	1,667,760.00	959,700.00
210402	Тээвэр, шатахуун	21,840,790.00	22,135,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,000.00	2,016,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	205,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,965,664.76	13,108,980.00

**Баянхонгор аймгийн Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2105	Нормативт зардал	27,605,857.80	26,305,013.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,008,791.80	17,541,063.00
210502	Хоол, хүнс	6,597,066.00	7,508,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,255,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	850,000.00	1,638,000.00
210604	Урсгал засвар	850,000.00	1,638,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,378,000.00	1,057,000.00
210702	Дотоод албан томилолт	2,378,000.00	1,057,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	1,083,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,083,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,914,233.27	27,781,153.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,760,860.00	4,349,110.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,153,373.27	23,432,043.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,957,793.20	14,352,096.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	7,972,176.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	7,972,176.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,639,727.00	99,345.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,639,727.00	99,345.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	318,066.20	6,280,575.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	318,066.20	6,280,575.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1,076,029.61	137,506,891.64
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-82,714,433.25	137,506,891.64

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	363,801,480.00	395,239,216.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	363,701,480.00	395,239,216.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	318,383,800.00	333,572,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	318,383,800.00	333,572,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	9,055,376.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	9,055,376.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,583,900.00	23,683,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,583,900.00	23,683,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,733,780.00	28,927,940.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,733,780.00	28,927,940.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	352,497,580.00	388,484,216.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,497,580.00	388,484,216.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,539,786.80	374,132,120.00

Баянхонгор аймгийн Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,995,300.00	257,234,031.00
210101	Үндсэн цалин	169,316,200.00	179,244,626.33
210102	Нэмэгдэл	47,808,700.00	60,794,614.07
210104	Урамшуулал	12,870,400.00	17,194,790.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,624,167.00	35,042,800.00
210201	Тэтгэврийн даатгал	19,290,300.00	24,579,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,364,800.00	2,615,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,814,786.00	2,092,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	424,681.00	523,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,729,600.00	5,231,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,944,173.00	20,302,055.00
210301	Гэрэл, цахилгаан	1,552,113.00	1,902,055.00
210302	Түлш, халаалт	13,992,060.00	18,200,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,314,039.00	25,846,140.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,174,500.00
210402	Тээвэр, шатахуун	20,690,090.00	19,865,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,000.00	2,016,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,407,949.00	1,840,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	950,000.00
2105	Нормативт зардал	30,868,741.80	18,767,584.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,458,791.80	11,212,584.00
210502	Хоол, хүнс	6,899,950.00	6,300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,510,000.00	1,255,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,711,700.00	3,282,500.00
210604	Урсгал засвар	2,010,000.00	3,282,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,818,000.00	1,057,000.00
210702	Дотоод албан томилолт	1,818,000.00	1,057,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000.00	1,483,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,083,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,863,666.00	11,116,810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,863,666.00	11,116,810.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,957,793.20	14,352,096.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	7,972,176.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	7,972,176.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,639,727.00	99,345.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,639,727.00	99,345.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	318,066.20	6,280,575.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	318,066.20	6,280,575.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,303,900.00	6,755,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	11,303,900.00	6,755,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,303,900.00	6,755,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,303,900.00	6,755,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,303,900.00	6,755,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-11,303,900.00	-6,755,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,933,621.64	58,649,953.03	-51,506,485.92	00.00	304,077,088.75
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,933,621.64	58,649,953.03	-51,506,485.92	00.00	304,077,088.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,933,621.64	58,649,953.03	-51,506,485.92	00.00	304,077,088.75
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	137,506,891.64	00.00	137,506,891.64
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,933,621.64	58,649,953.03	86,000,405.72	00.00	441,583,980.38

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Дүн	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	386,185,600.00	379,803,920.00	6,381,680.0	98.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,185,600.00	379,803,920.00	6,381,680.0	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,185,600.00	379,803,920.00	6,381,680.0	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,589,400.00	257,234,031.00	4,355,369.0	98.3
210101	Үндсэн цалин	183,429,800.00	179,244,626.33	4,185,173.7	97.7
210102	Нэмэгдэл	59,816,600.00	60,794,614.07	-978,014.1	101.6

**Баянхонгор аймгийн Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210104	Урамшуулал	18,343,000.00	17,194,790.60	1,148,209.4	93.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,042,800.00	35,042,800.00	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	24,579,200.00	24,579,200.00	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,615,900.00	2,615,900.00	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,092,700.00	2,092,700.00	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	523,200.00	523,200.00	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,231,800.00	5,231,800.00	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,401,400.00	20,302,055.00	99,345.0	99.5
210301	Гэрэл, цахилгаан	1,928,200.00	1,902,055.00	26,145.0	98.6
210302	Түлш, халаалт	18,273,200.00	18,200,000.00	73,200.0	99.6
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00	0.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	26,305,000.00	25,846,140.00	458,860.0	98.3
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,174,500.00	25,500.0	97.9
210402	Тээвэр, шатахуун	20,139,000.00	19,865,640.00	273,360.0	98.6
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	2,016,000.00	2,016,000.00	0.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,840,000.00	160,000.0	92.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950,000.00	950,000.00	0.0	100.0
2105	Нормативт зардал	18,963,700.00	18,767,584.00	196,116.0	99.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,408,700.00	11,212,584.00	196,116.0	98.3
210502	Хоол, хүнс	6,300,000.00	6,300,000.00	0.0	100.0
210503	Нормын хувцас, зоолон эдлэл	1,255,000.00	1,255,000.00	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,132,500.00	9,132,500.00	0.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,850,000.00	5,850,000.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	3,282,500.00	3,282,500.00	0.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,657,200.00	1,057,000.00	600,200.0	63.8
210702	Дотоод албан томилолт	1,657,200.00	1,057,000.00	600,200.0	63.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000.00	400,000.00	0.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,693,600.00	12,021,810.00	671,790.0	94.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,693,600.00	12,021,810.00	671,790.0	94.7
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>386,185,600.00</b>	<b>381,544,113.00</b>	<b>4,641,487.0</b>	<b>98.8</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>333,572,000.00</b>	<b>333,572,000.00</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	333,572,000.00	333,572,000.00	0.0	100.0
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>23,683,900.00</b>	<b>19,044,173.00</b>	<b>4,639,727.0</b>	<b>80.4</b>
132001	Орон нутгийн төсвөөс	23,683,900.00	19,044,173.00	4,639,727.0	80.4
1340	нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	28,929,700.00	28,927,940.00	1,760.0	100.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28,929,700.00	28,927,940.00	1,760.0	100.0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>22.00</b>	<b>20.00</b>	<b>2.0</b>	<b>90.9</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	15.00	1.0	93.8
620003	Үйлчлэх ажилтан	05.00	04.00	1.0	80.0
64	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	<b>186.00</b>	<b>82.00</b>	<b>104.0</b>	<b>44.1</b>
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>22.00</b>	<b>20.00</b>	<b>2.0</b>	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ГЗ)	01.00	01.00	0.0	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч	16.00	15.00	1.0	93.8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ГҮ)	05.00	05.00	0.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НТ-2

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		9,055,376
21	УРСГАЛ ЗАРДАЛ		9,055,376
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	9,055,376
2132	Бусад урсгал шилжүүлэг		9,055,376
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		9,055,376
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	9,055,376
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		9,055,376
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,055,376
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баянговь сумын эрүүл мэндийн төвийн дарга М.Өлзийжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 12-аас 2021 оны 02 дугаар сарын 15-ний хооронд Баянхонгор аймаг дахь Глобал Капитал аудит ХХК-ны газрын аудитор Д.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дүгээр сарын 23-ний өдрийн 60 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Хүн ардынхаа эрүүл мэндийг сайжруулахад үйлчлүүлэгчдэдээ хамгийн ээлтэй тусламж үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагаар итгэл хүлээлгэхийг эрмэлзэнэ.гэсэн зорилтыг тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

### **3.3 Нягтлан БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ**

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа орон нутаг дахь Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 350522,3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7010,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 424337,6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8486,7 мянган төгрөгөөр тооцов.

### **3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Баянговь сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 445228.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 138150.9 мянган төгрөгөөр буюу 46,4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	11,385.4	19,619.4	8,234.1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,144.2	58.0	(2,086.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	9,241.2	19,561.4	10,320.3
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	292,691.7	425,608.6	132,916.9
Үндсэн хөрөнгө	384,534.6	540,883.5	156,348.9
Хуримтлагдсан элэгдэл	(91,842.9)	(115,274.9)	(23,432.0)
<b>Нийт хөрөнгө</b>	304,077.1	445,228.0	141,151.0
Өр төлбөр	-	3,644.1	3,644.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	304,077.1	441,584.0	137,506.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	304,077.1	445,228.0	141,151.0

Бараа материалын дансны үлдэгдэл 19561.4 мянган төгрөг болж 10320.3 мянган төгрөгөөр өссөн нь эм, эмнэлгийн хэрэгслийн дансны үлдэгдэл өмнөх оноос 8922.2 мянган төгрөгөөр нэмэгдэж цар тахлын үед бэлэн байдлыг хангах зорилгоор 18126.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй, 8922.2 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг төсвийн хөрөнгөөр худалдан авч нөөцөлсөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 540883,5 мянган төгрөг болж 156348,9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6755,0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эмнэлгийн барилгын их засварыг Тэнгэрийн уул ХХК - гүйцэтгэж, 149593,9 мянган төгрөгөөр хийснийг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 121 тоот тогтоолын дагуу орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 441583.9 мянган төгрөг болж 137506.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 137506.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 561844.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 186943.0 мянган төгрөгөөр буюу 33.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөв байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 186943,0 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээж авсан хөрөнгө болон материалын орлого 157683,3 нэмэгдсэнтэй, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 7194,1 мянган төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн дансанд ажилчдын 5 жилийн тэтгэмж 7972,2 мянган төгрөгөөр цар тахалтай холбоотой 1083,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Нийт зардал 424337,6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 48360,1 мянган төгрөгөөр буюу 11,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 318470,8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 318470,8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 66714.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хасаж 385185.7 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төлөвлөгөөг 1 удаа тодотгол хийж 391125,3 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 386185,6 мянган төгрөгийн төсөв баталснаас 352616,2 мянган төгрөгийг улсын төсвөөс 28927,9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71602 хөтөлбөрийн 80109 арга хэмжээ 4185,2 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан /хөтөлбөр арга хэмжээгээр/

мянган.төг

№	Үзүүлэлт		Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>НИЙТ</b>		<b>391,125,300.00</b>	<b>384,143,420.00</b>	<b>6,981,880.00</b>	<b>98.30</b>
1	<b>Хөтөлбөр 71602</b>	<b>Баянговь сумын Эрүүл мэндийн төв</b>	<b>386,185,600.00</b>	<b>379,803,920.00</b>	<b>6,381,680.00</b>	<b>98.3</b>
2	<b>80109</b>	<b>ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал</b>	<b>23,683,900.00</b>	<b>23,584,555.00</b>	<b>99,345.00</b>	<b>99.6</b>
3	210301	Гэрэл, цахилгаан	1,928,200.00	1,902,055.00	26,145.00	98.6
4	210302	Түлш, халаалт	18,273,200.00	18,200,000.00	73,200.00	99.6
5	210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00	0.00	100.0
6	210604	Урсгал засвар	3,282,500.00	3,282,500.00	0.00	100.0
14	<b>81603</b>	<b>Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ</b>	<b>340,717,500.00</b>	<b>335,113,603.00</b>	<b>5,603,897.00</b>	<b>98.4</b>
15	210101	Үндсэн цалин	183,429,800.00	179,244,626.33	4,185,173.67	97.7
16	210102	Нэмэгдэл	59,816,600.00	60,794,614.07	-978,014.07	101.6
17	210104	Урамшуулал	18,343,000.00	17,194,790.60	1,148,209.40	93.7
18	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	24,579,200.00	24,579,200.00	0.00	100.0
19	210202	Тэтгэмжийн даатгал	2,615,900.00	2,615,900.00	0.00	100.0
20	210203	ҮОМШ-ний даатгал	2,092,700.00	2,092,700.00	0.00	100.0
21	210204	Ажилгүйдлийн даатгал	523,200.00	523,200.00	0.00	100.0
22	210205	Эрүүл мэндийн даатгал	5,231,800.00	5,231,800.00	0.00	100.0
23	210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,174,500.00	25,500.00	97.9
24	210402	Тээвэр (шагахуун)	20,139,000.00	19,865,640.00	273,360.00	98.6
25	210403	Шуудан холбоо, нигернэтийн төлбөр	2,016,000.00	2,016,000.00	0.00	100.0
26	210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	2,000,000.00	1,840,000.00	160,000.00	92.0
	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	950,000.00	950,000.00	0.00	100.0
	210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,568,100.00	8,378,632.00	189,468.00	97.8
	210502	Хоол, хүнс	6,300,000.00	6,300,000.00	0.00	100.0
	210503	Нормын хувиас зоолон эдлэл	1,255,000.00	1,255,000.00	0.00	100.0
	210702	Дотоод албан томилолт	1,657,200.00	1,057,000.00	600,200.00	63.8
29	<b>80302</b>	<b>Нэг иргэнд ногдох нормативаар</b>	<b>21,784,200.00</b>	<b>21,105,762.00</b>	<b>678,438.00</b>	<b>96.9</b>
30	210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,840,600.00	2,833,952.00	6,648.00	99.8
31	210601	Багаж, техник, хэрэгсэл	5,850,000.00	5,850,000.00	0.00	100.0
32	210802	Аудит баг, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00	0.00	100.0
33	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,693,600.00	12,021,810.00	671,790.00	94.7

/Эх сурвалж: 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн газраас ажилчдын 5 жилийн тэтгэмжийн санхүүжилт 7972,2 мянган төгрөг, 1083,2 мянган төгрөг нийт 9055,4 мянган төгрөгийн орлого орж, зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 116 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан байна. Аймгийн СХАА-аас нэмэлт зааварчилгаа өгсний улмаас дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас 35 мэдээ хугацаа хоцорч мэдээлэгдсэн төлөвт шилжсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	4	
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	31	5	
5	Тухай бүр	8	96	71	25	
	Нийт	27	151	116	35	

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг хугацаанд нь бүрэн биелүүлж, 100 хувийн биелэлттэй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21185,6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 4309,5 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 3 заалт бүхий зөвлөмж өгөв.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Аймгийн Эрүүл мэндийн газраас авсан тендерийн эмээс 1107,9 мянган төгрөгийн эмийн тайланг нярав гаргаагүй, мөн хандив тусламжаар ирсэн эм болон эмнэлгийн материалын орлогоос 3201,6 мянга, нийт 4309,5 мянган төгрөгийн хөрөнгийг эмийн тайланд орлогыг дутуу бүртгэсэн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд 4309,5 мянган төгрөгийн эмийг бараа материалын дансанд бүртгэж залруулга хийв.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Аймгийн ЭМГ-аас тайлант онд 14976,4 мянган төгрөгийн тендерийн эмийг үнэ төлбөргүй нийлүүлсэн ба тайлант оны эцэст сумын ЭЭС-д 8488,6 мянган төгрөгийн эм байгааг тус байгууллага хүлээн аваагүй тул тайланд тусгаагүй иймд тухайн байгууллагад үлдэгдлээр байгаа эмийн зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна.

## **Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал**

**1.1.1.Илрүүлэлт:** Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 116 мэдээллээс бүтэн жилээр байршуулах 4 төрлийн 4 мэдээлэл, хагас жилээр байршуулах 2 төрлийн 1 мэдээлэл, сараар байршуулах 2 төрлийн 5 мэдээлэл, тухай бүр байршуулах 4 төрлийн 25 мэдээлэл, нийт 35 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

#### **1.1.2. Эрсдэл:** Хуулийн хэрэгжилт хангалтгүй

**1.1.3.Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны сайтад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан хугацаанд мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

#### **1.1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**2.1.1.Илрүүлэлт:** 2.Эмийн тайланг гаргаагүй эмийн түүврээр орлого зарлага гаргасан мөн тайлан гаргаж анхан шатны баримтыг бүрэн хөтлөөгүй байхад нягтлан бодогч 1107,9 мянган төгрөгийг журналын бичилтээр зардал гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэсэнтэй нийцэхгүй байна.

#### **2.1.2. Эрсдэл:** Хуулийн хэрэгжилт хангалтгүй

**2.1.3.Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "13.6 Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." "13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтуудыг хэрэгжүүлж анхан шатны баримтад үндэслэн тайланг гаргаж байх.

#### **2.1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**3.1.1.Илрүүлэлт:** Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах зөвлөмжийг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн байхад бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн" 8.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20,20,2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийн зохион байгуулах" гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

3.1.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангалтгүй

3.1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн" 8.2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20,20,2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийн зохион байгуулах" гэсэн заалтуудыг мөрдөж НБББББ-ийг боловсруулж мөрдөж ажиллах. .

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Д.ЭНХТУЯА

Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН  
МЕНЕЖЕР



А.ЦЭЭНЯМ

Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР.....

Б.МӨНХБАТ

Огноо: 2021.02.25

#### 4. Хавсралт:Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			БНА-2021/20/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор аймгийн Баянговь сумын Эрүүл мэндийн төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 116 мэдээллээс бүтэн жилээр байршуулах 4 төрлийн 4 мэдээлэл, хагас жилээр байршуулах 2 төрлийн 1 мэдээлэл, сараар байршуулах 2 төрлийн 5 мэдээлэл, тухай бүр байршуулах 4 төрлийн 25 мэдээлэл, нийт 35 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.		Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	М.Өлзийжаргал Б.Өнөрмандах
2	Аймгийн Эрүүл мэндийн газраас авсан тендерийн эмээс 1107,9 мянган төгрөгийн эмийн тайланг нярав гаргаагүй, мөн хандив тусламжаар ирсэн эм болон эмнэлгийн материалын орлогоос 3201,6 мянга, нийт 4309,5 мянган төгрөгийн хөрөнгийг эмийн тайланд орлогыг дутуу бүртгэсэн байна.	4309,5	Санхүүгийн тайланд авлагаар залруулах	Дарга Нягтлан бодогч	М.Өлзийжаргал Б.Өнөрмандах
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах зөвлөмжийг 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн байхад бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй		Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	М.Өлзийжаргал Б.Өнөрмандах
4	Эмийн тайланг гаргаагүй эмийн түүврээр орлого зарлага гаргаж, 16876,1 мянган төгрөгийн эмийг зарцуулсан, мөн тайлан гаргаж анхан шатны баримтыг бүрэн хөтлөөгүй байхад нягтлан бодогч 1107,9 мянган төгрөгийг журналын бичилтээр зардал гаргасан байна.	16876,1	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	М.Өлзийжаргал Б.Өнөрмандах
<b>ДҮН</b>		<b>21185,6</b>			